



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/222.

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 203 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Журам батлах тухай" А/139 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай" 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, ажиллах чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв)-д даалгасугай.

3. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний нэхэмжлэлд тавигдах чанар, төлбөрийн хяналтын шалгуурын дагуу явцын болон гүйцэтгэлийн хяналт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга (А.Эрдэнэтунгалаг)-д үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тооцон нөөц бүрдүүлж, бэлэн байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Иргэдийн үзлэг шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх, зар мэдээлэл хүргэх, эрүүл мэндийн байгууллагуудын урвалж оношлуур, эм эмнэлгийн хэрэгслийн хангалт, нөөцийн бэлэн байдлыг хангаж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Сайнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0480

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 02-ны өдрийн
А/ЗД/2022 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: С.Ундрах (аймгийн Засаг даргын орлогч)
- Нарийн бичгийн дарга: Ц.Сонинбаяр (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Гишүүд:
- Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга)
 - Э.Хүдэрчулуун (аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал)
 - А.Эрдэнэтунгалаг (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга)
 - Н.Оюунтуяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга)
 - Ю.Ичинноров (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга)
 - М.Золзаяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)
 - Я.Жаргал (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга)
 - Б.Валя (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ерөнхий санхүүч)

-оОо-

АЖЛЫН ХЭСГИЙН ЧИГ ҮҮРЭГ

Нэг. Ажлын хэсгийн ахлагчийн үүрэг

1.1. Хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулах ажлыг ерөнхий зохион байгуулалтаар хангаж ажиллах,

1.2. Багийн гишүүдийн чиг үүргийг уялдуулах, хянах, үүрэгжүүлэх,

1.3. Байгууллага аж ахуйн нэгж, баг, хорооны иргэдийг бүрэн хамруулах ажлыг салбар дундын оролцоотой зохион байгуулах,

1.4. Явцын мэдээнд дүгнэлт хийж, эрчимжүүлэх, үр дүнг тооцох,

1.5. Тулгамдсан асуудлыг тодорхойлон дээд шатны байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх.

Хоёр. Ажлын хэсгийн гишүүдийн үүрэг

2.1. Эрүүл мэндийн газар

2.1.1. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулахад харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийг хамруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж явцад хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах,


2.1.2. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог үндсэн тусламж үйлчилгээний хүртээмж, оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулах,

2.1.3. Эрт илрүүлгийн мэдээ мэдээллийн шуурхай үнэн зөв байдлыг хангаж, тайлан хүлээн авч нэгтгэн, сар бүр дээд шатны байгууллагад мэдээлэх,

2.1.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслэл, урвалж бодис, бүртгэлийн маягт, цахим программ, хүний нөөцийн хангамж, сургалтын хэрэгцээнд үнэлгээ хийж, шаардагдах төсвийн саналыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх,

2.1.5. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны товллол, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх журмын талаар иргэдийг нээлттэй ил тод мэдээллээр хангах,

2.1.6. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны талаарх мэдээлэл, сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах.



2.2. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

2.2.1. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцын талаарх мэдээллийг өөрийн цахим хуудаст ил тод, ойлгомжтой хэлбэрээр байршуулж сурталчлах, даатгуулагчийг мэдээллээр хангах,

2.2.2. Эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний нэхэмжлэлд тавигдах чанар, төлбөрийн хяналтын шалгуурын дагуу явцын болон гүйцэтгэлийн хяналт хийх,

2.2.3. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдсан даатгуулагчийн зардлын мэдээллийг даатгуулагч бүрээр шалгаж, зардлын нөхөн төлбөрийг холбогдох журмын дагуу хянаж, гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх,

2.2.4. Даатгуулагчаас ирүүлсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагатай холбоотой тусламж, үйлчилгээний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх,

2.2.5. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний нэхэмжлэлд гарсан алдаа, зөрчлийг сар бүр тухайн байгууллага болон Эрүүл мэндийн газарт мэдээлэх,

2.2.6. Иргэдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг сурталчлах, эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх.

2.3. Сумын Засаг дарга нар

2.3.1. Харьяа нутаг дэвсгэрийн насанд хүрэгчдийг аймгийн төвийн лавлагаа шатлалын эмнэлэгт урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, хариуцан гүйцэтгэх,

2.3.2. Алслагдсан болон хөгжлийн бэрхшээлтэй биеэр ирэх боломжгүй иргэдэд хүрч үйлчлэхэд шаардагдах, эм эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, машин техникийн дэмжлэг үзүүлэх,

2.3.3. Иргэдэд мэдээлэл сурталчилгааг хүргэх, хамрагдалтыг нэмэгдүүлэхэд салбар дундын оролцоотойгоор хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй иргэдийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах,

2.3.4. Үзлэгийн хамрагдалтын явцад хяналт хийх хариу арга хэмжээ зохион байгуулах,

2.3.5. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвд хийгдэх хүүхдийн эрт илрүүлэх үзлэгийн зохион байгуулалт, хамралтад дэмжлэг үзүүлэх,

2.4. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд

2.4.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах хүн амын судалгааг гаргаж, үндсэн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр, иргэдэд чирэгдэлгүйгээр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах,

2.4.2. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг хийх эмч, мэргэжилтнийг ажлын давхардал үүсгэхгүйгээр томилох, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах,

2.4.3. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд шаардагдах өрөө тасалгаа, багаж тоног төхөөрөмж, урвалж бодисын хэрэгцээг тодорхойлж, захиалга хийж, бэлэн байдлыг хангаж ажиллах,

2.4.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний явцын мэдээ тайлангийн үнэн зөв, шуурхай байдлыг ханган ажиллах,

2.4.5. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны талаарх мэдээлэл, сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах.